

Удиртгал



УДИРТГАЛ

Учир нь хүн бүх дэлхийг олж авсан ч амиа алдвал ямаршиг байх билээ? Эсвэл амийнхаа оронд юугаа өгөхбилээ? (Матай 16:26)

Бидэнд Христээр дамжуулан Бурханд хандах тийм бат итгэл байдаг. Бид ямарнэгэн юмыг өөрсдөөсөө гаргадаг юм шиг шаардаж чадахгүй. Харин бидний чадвар Бурханаас гардаг юм. Тэр биднийг үсгээр бус, харин Сүнсээр шинэ гэрээний үйлчлэгчид байх чадвартай болгожээ. Учир нь үсэг бол хөнөөдөг харин Сүнс бол амь өгдөг аж.(1Коринт 3:4-6).

Бид энэ дэлхийг эсвэл амийг зохион бүтээгээгүй. Амийг Бүтээгч Бурхан өгдөг. Энэ бол мөнхийн амьдрал, мөн хийн шагнал авах боломж юм.

1. ДУУДЛАГА

Ариун газар: Ариунаас/ариун

Цугларах газраа Рамагийн Наиот/Дээд өрөө, Тураннын сургууль шиг болгоорой.

(1 Самуел 19:19; Үйлс 1:13; 19: 9)

Ариун Сүнсийг урь.

Харин Туслагч буюу Миний нэрээр Эцэгийн минь илгээх Ариун сүнс та нарт бүх зүйлийг заах бөгөөд Миний та нарт хэлсэн бүгдийг сануулах болно.(Иохан 14:26)

Та нарын Түүнээс авсан тосолгоо нь та нарын дотор байдаг бөгөөд өөрсдөд чинь заах хэн нэгэн та нарт хэрэггүй. Харин Түүний тосолгоо нь та нарт бүхнийг заадаг бөгөөд тэрхүү тосолгоо нь худал биш, үнэн. Та нарт заасан ёсоор та нар түүний дотор байгтун.(1Иохан 2:27)

Би чиний явах ёстой замд чамд зааварлан зааж өгнө. Би чамайг ширтэн чамд зөвлөнө.(Дуулал32:8)

8 Өглөө бүр Та хайр энэрлээ надад сонсгооч. Учир нь би Танд итгэдэг билээ. Явах замыг минь надад зааж өгөөч. Танд л би сэтгэлээ өргөн барьж байна. (Дуулал 143:8)

Чиний Аврагч, Израилийн Ариун Нэгэн, Эзэн ингэж айлдаж байна." Би бол чиний Бурхан ЭЗЭН мөн. Би чамд тусгайг сурган, чамайг явах ёстой замаар чинь удирддаг.(Исаиа 48:17)

ЭЗЭНий номноос олоод уншигтун. Тэдгээрийн нэг нь ч алга болохгүй, нэг нь ч ажлаа алдахгүй. Учир нь түүний ам алдаж, Түүний Сүнс тэднийг цуглуулсан юм.

Тэр тэдний төлөө шаваг хаясан. Түүний мутар үүнийг тэдэнд хэмжээгээр нь хувааж өгсөн. Тэд энэ газрыг мөнхөд эзэмшиж, үеийн үед энд орших болно. (Исаиа 34:16-17)


Бурханд хандан хашхир

Иабез Израйлийн Бурханд хандан" Өө, Та үнэхээр намайг ерөөх болтугай ! Хил хязгаарыг нь өргөсгөж, Таны мутар надтай хамт байж, Та намайг гай гамшгаас хамгаалж, өвчин зовлон намайг бүү өртүүлээч !гэж хүссэн бөгөөд Бурхан түүний хүслийг гүйцэлдүүлж өгчээ.(Шастирийн дээд 4:10)

Тухайн Сүмийг юу бусдаас ялгаатай болгодог вэ?

Хэрэв Пентекостын өдрийн дараа шавь нарын хандлагын (эв нэгдэл, бие биенээ хайрлах) өөрчлөлт болон Ариун Сүнсний илэрц байхгүй байсан бол Сүм нь аливаа зан үйл, бусад байгууллагаас ялгарч чадах байсан болов уу?

1.1 ШҮҮДЭР СЭДВИЙН ЖАГСААЛТ



Миний хургануудыг тэжээ

Миний хоньдыг хариул

Миний хоньдыг тэжээ

- 1. Бурхан бидэнд Библийг өгсөн зорилгыг таних мэдэх
- 2. Бүтээгч Бурханыг мэдэх
- 3. Бурханы Шүүлт, Шударга ёс, Хайр

- 4. Би хэн бэ?/ Би хаана байна вэ?/ Онцгой дуудлага/ Томоор харах
- 5. Амьд Бурхантай хамт алхах

- 6. ШҮҮДЭР хичээл заах багшийн “Хэвийн” шалгуурын жагсаалт
- 7. ШҮҮДЭР лекторын анги

15 Тэднийг өглөөний хоолоо идэж дуусахад Есүс Симон Петрт — Иоханы хүү Симон оо, чи Намайг тэднээс илүү хайрладаг уу? гэж асуухад тэр —Тийм ээ, Эзэн. Миний Танд хайртайг Та мэднэ гэж хэлэв.

Есүс түүнд —**Миний хургануудыг гэжээ** гэлээ.

16 Есүс дахин хоёр дахь удаагаа түүнд —Иоханы хүү Симон оо, чи Намайг хайрладаг уу? гэхэд тэр Түүнд —Тийм ээ, Эзэн. Миний Танд хайртайг Та мэднэ гэв.

Есүс түүнд —**Миний хоньдыг хариул** гэлээ. 17 Есүс түүнд гурав дахь удаагаа —Иоханы хүү Симон оо, чи Намайг хайрладаг уу? гэв. “Чи Намайг хайрладаг уу?” гэж Есүс гурвантаа асуусан учир Петр гуниглав. Тэр —Эзэн, Та бүх юмсыг мэддэг. Миний Танд хайртайг Та мэднэ гэв.

[Есүс] түүнд —**Миний хоньдыг гэжээ.** (Иохан 21:15 – 17)

1.2 СҮНСНИЙ БАЙДЛАА ХЯНАХУЙ

а. Түүний нэрийг дуудахад Тэр тантай хамт байгаа гэдэгт та итгэдэг үү?

б. Та Түүн дээр ирэхэд Тэр таныг шагнах болно гэдэгт та итгэдэг үү?

в. Та өөрийн зүрх сэтгэлийг шалгахыг Ариун Сүнснээс асууж болох уу?

г. Санаанд тань оруулсан бүх зүйлд та нэг бүрчлэн гэмшсэн үү?

д. Та Ариун Сүнснээс өөртөө заалгахыг гуйсан уу?

е. Та Ариун Сүнсийг дагахад бэлэн үү?

ё. Түүний Таниас хүссэн бүх зүйлийг та дагах уу?

Өнөөдрийн чин үнэнч байдал нь маргаашийн ерөөлийн зам дээр байх эсэхийг шийдэх болно. Ерөөл, бэлгийг танд аль хэдийн бэлдсэн байгаа хэдий ч өнөөдрийн үүрэг, хариуцлагаа биелүүлэхгүй бол өгөх боломжгүй.

Өдрийн эцэст залбирлаар өндөрлөхийн ач холбогдлыг унтахаасаа өмнө ойлгоорой. Тэр төгс төгөлдөрийг бус эмтэрсэн зүрх, гэмшсэн сэтгэлийг эрэлхийлдэг нь таатай юм.

Израилчуудыг цөлд удирдсан нь Мосе биш харин Бурхан байсан гэдгийг санаарай. Мосе зүгээр л Бурханы тушаалыг биелүүлсэн. Ариун Сүнсээр удирдуулж дуулгавартай зарц байх. Мэддэг зүйлээ дагаж, юу сонсож байгаагаа хуваалцаарай. Хүнээс бус харин Сүнснээс суралц.

1.3 ТЭНГЭРИЙН ШАГНАЛ

12 Хэрэв хэн нэгэн хүн энэ суурин дээр алт, мөнгө, эрдэнийн чулуу, мод, өвс болон сүрлээр баривал, 13 ажил болгон нь илэрхий болно. Учир нь мөнөөх өдөр үүнийг харуулна. Яагаад гэвэл энэ нь галаар илэрхий болгогдох бөгөөд гал нь хүн бүрийн ажлын чанарыг шалгах болно. 14 Хэрэв хэн нэгний үүн дээр барьсан ажил нь үлдвэл тэр хүн шагналаа хүлээн авна. 15 Хэрэв хэн нэгний ажил шатвал тэр хүн хохирол амсана. Тэр өөрөө гал дундуур гарсан мэт боловч аврагдана. (1 Коринт 3:12 - 15)

1.4 ОЙЛГОХ, ХАРАХ НҮД БА СОНСОХ ЧИХ

2 Мосе бүх Израилийг дуудан тэдэнд хэлсэн нь —Египетийн нутагт Фараонд болон түүний бүх түшмэдэд, түүний бүх газар нутагт ЭЗЭНий үйлдсэн бүхнийг та нар нүдээрээ үзсэн. 3 Та нар их сорилт, агуу тэмдэг, гайхамшигийг нүдээрээ үзсэн билээ. 4 Харин ЭЗЭН өнөөдрийг хүртэл та нарт ойлгох ухаан, харах нүд, сонсох чихийг өгөөгүй. (Дэд хууль 29:2 - 4)

□ Таны зүрх сэтгэлийг юу нээж болохыг та мэдэх үү?

13 Харин Түүний амлалтын дагуу бид зөвт байдал оршдог шинэ тэнгэр, шинэ газрыг хүлээн байна. 14 Тиймээс хайртууд минь, та нар эдгээрийг хүлээж буй учраас амар амгалан дотор болон толбогүй бөгөөд гэм зэмгүйгээр Түүнд олдохыг хичээгтүн. (2 Петр 3:13 - 14)

23 Есүс түүнд —“Хэрэв Та чаддаг бол” гэв үү? Итгэлтэй хүнд бүх юм боломжтой гэхэд,(Марк 9:23)

□ Бурханд бүх зүйл боломжтой гэдэгт та итгэдэг үү?

6 бас өөр газар “Чи бол Мелхизедекийн хэргэмийн дагуу Мөнхийн Тахилч юм” гэж Айлдагч нь алдаршуулсан юм. 7 Тэрээр махан биеийнхээ өдрүүдэд Өөрийг нь үхлээс аварч чадах Нэгэнд чанга хашхиран, нулимсаараа залбирал болоод гуйлтуудаа өргөсөн. Тэр сүжигтэй байсан тул Бурхан Түүнийг сонссон билээ. 8 Тэр Хүү нь байсан хэрнээ зовсон зүйлсээсээ дуулгавартай байдалд суралцсан. 9 Тэр төгс болгогдсоноороо Өөрт нь дуулгавартай байдаг бүх хүнд мөнх авралын эх үндэс нь болсон бөгөөд (Еврей 5:6 – 9)

□ Таны амьдрал дахь ерөөлүүдийг юу зогсоодгийг та мэдэх үү?

1.5 Эрэгцүүлэх АСУУЛТУУД

- а) Би хэн бэ?
 - б) Хэн надад энэ амьдралыг өгсөн бэ?
 - в) Хэн миний амьдралыг төгсгөж, там эсвэл диваажин руу явуулж чадах вэ?
 - г) Тэнгэр ба газрын эзэн хэн бэ?
 - д) Түүний дотор байгаа бүх зүйлийг хэн эзэмшдэг вэ?
 - е) Тэр Өөрийн эзэмшлээрээ юу хийх гэж байгаа вэ?
 - ё) Миний итгэдэг зүйл зөв гэдгийг би яаж мэдэх вэ?
 - ж) Энэ нь зөв болохыг юу баталж байна вэ?
 - з) Бурханыг Бурхан болгодог нь юу вэ?
 - к) Бурханы тухай олон номд өгүүлдэг ч аль нь зөв бэ?
 - л) Энэ нь зөв гэдгийг юу баталж байна вэ?
 - м) Хэрэв энэ нь туйлын зөв бол хэзээ ч өөрчлөгдөх ёсгүй. Тийм биз дээ?
 - н) Хэрэв энэ нь хүчирхэг бол хэлснийхээ дагуу хийх ёстой. Тийм биз дээ?
 - о) Хэрэв энэ нь амьд байгаа бол бид үүнийг амьд гэж үзэх ёстой бөгөөд мэтгэлцэх шаардлагагүй болно. Бид тэгэх үү?
 - ө) Ирээдүйд юу болохыг хэн хэлэх вэ? Үүнийг хэн хийдэг вэ?
 - п) Бүтээгчийг хараад теллус руу ирсэн хүн байна уу?
 - р) Хүн бүр алж, устгаж чадна, гэхдээ хэн үхлээс амь руу авчирч чадах вэ?
 - с) Туйлын хүч чадалгүйгээр дэлхий дээр амар амгалан байж чадах уу?
 - т) Энэхүү үнэмлэхүй хүч дэлхий дээр хэзээ болохыг би мэдэх үү?
 - у) Надад Ариун Сүнсний хүчирхэг бэлгүүд бий юу?
 - ү) Дуудлагаа юу болохыг би мэдэх үү?
 - ц) Бурхан яагаад бидэнд эрх чөлөө өгсөн бэ?
 - ч) Бүх бодгаль мөнхөд хаана амьдрахыг та мэдэх үү?
 - ш) Үл үзэгдэх ертөнц маш том гэдгийг та мэдэх үү?
-